

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны ... дугаар  
сарын .... -ны өдөр

Дугаар ....

Улаанбаатар  
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох журмыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяад, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

## **Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж олгох журам**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг болон тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Ажил олгогч нь ажилтанд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг хуульд заасан хугацаанд бүрдүүлж өгнө.

### **Хоёр.Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг**

2.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгоход доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

2.1.1.тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл;

2.1.2.иргэний үнэмлэх;

2.1.3.хөдөлмөрийн чадвар алдсан тухай Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр;

2.1.4.хөдөлмөрийн эсхүл эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт”;

2.1.5.нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт;

2.1.6.ажилд томилсон тухай тушаал;

2.1.7.цалингийн тодорхойлолт (1 сараас доош хугацаанд ажилласан).

2.2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан даатгуулагчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгоход дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

2.2.1.энэ журмын 2.1-т заасан баримт бичгүүд;

2.2.2.тэжээгчийн нас барсны гэрчилгээ;

2.2.3.тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн төрсний гэрчилгээ, ам бүлийн тодорхойлолт;

2.2.4.тэжээгчийн гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд нь төрөлхийн буюу 16 насанд хүрээгүй байхдаа хөдөлмөрийн чадвар алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоосон Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэр;

2.2.5.гэрлэлтийн гэрчилгээний хуулбар, эсхүл архивын лавлагаа, шүүхийн шийдвэр;

2.2.6.асран хамгаалагчаар тогтоосон тухай харьяалах сум, дүүргийн Засаг даргын захирамж;

2.2.7.тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд хуваан олгох тохиолдолд холбогдох өргөдөл, шүүхийн шийдвэр.

### **Гурав.Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичиг**

3.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

3.1.1.тэтгэмж авах тухай өргөдөл;

3.1.2.эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудас;

3.1.3.хөдөлмөрийн эсхүл эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт”;

3.1.4.нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт;

3.1.5.иргэний үнэмлэх.

3.2.Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж авахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

3.2.1.тэтгэмж авах тухай өргөдөл;

3.2.2.даатгуулагчийн нас барсны гэрчилгээ;

3.2.3.хөдөлмөрийн эсхүл эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт”;

3.2.4.нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт;

3.2.5.ар гэрийн гишүүний иргэний үнэмлэх.

### **Дөрөв.Тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтооход шаардагдах баримт бичиг**

4.1.Тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоохдоо Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасан тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоох дараах үндэслэлийг баталгаажуулсан баримт бичгийг бүрдүүлнэ:

4.1.1.тэтгэвэр тогтоолгоход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ өөрчлөгдсөн тухай;

4.1.2.хөдөлмөрийн чадвар алдалтын хувьд өөрчлөлт орсон тухай;

4.1.3.нас барсан тэжээгчийн асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй гишүүний тоонд өөрчлөлт орсон тухай;

4.1.4.тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш 12 сараас доошгүй хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тухай зэрэг тус тус болно.

### **Тав.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр олгох**

5.1.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэврийг нийгмийн даатгалын байгууллага банкаар дамжуулан сар бүр олгоно.

5.2.Хөдөлмөрийн чадвараа 30 хүртэл хувиар байнга алдсан даатгуулагчийн 6 жилд ногдох, удаан хугацаагаар алдсан даатгуулагчийн эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн тогтоосон хугацаанд ногдох хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэврийг өөрийнх нь хүсэлтээр нэг удаа олгож болно. Энэ тохиолдолд уг тэтгэврийг тогтоолгосон шалтгаанаар хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэвэр авах эрх дуусгавар болно.

5.3. Даатгуулагч нас барсан бол дараагийн сарын тэтгэврийг олгохдоо даатгуулагчийн ар гэрийн гишүүний хүсэлт, иргэний үнэмлэхийг үндэслэнэ.

### **Зургаа. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэмж олгох**

6.1. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг Нийгмийн даатгалын байгууллага банкаар дамжуулан тухай бүр олгоно.

6.2. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны нэг сараас дээш хугацааны тэтгэмжийг 14 хоног тутам бодож олгоно.

### **Долоо. Бусад зүйл**

7.1. Даатгуулагч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг өөрийн биеэр бүрдүүлэх боломжгүй бол хууль ёсны төлөөлөгч нь дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

7.1.1. тэтгэвэр авагчийн хууль ёсны төлөөлөгчийг болон тэтгэвэр авагч иргэн эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон, чадамж хязгаарлагдсан бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тодорхойлсон шийдвэр;

7.1.2. хууль ёсны төлөөлөгчийн болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх.

7.2. Энэ журмын 7.1-д заасан хууль ёсны төлөөлөгч нь энэ журмын 2.1, 2.2, 3.1, 3.2, 4.1-т заасан баримт бичгийг бүрдүүлж өгнө.

7.3. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн тэтгэвэр тогтоолгох бол эрх бүхий байгууллагын олгосон Монгол Улсад байнга оршин суудаг болохыг баталгаажуулсан баримт бичгийг өгнө.

7.4. Энэ журмын 2.1, 2.2, 3.1, 3.2, 4.1-т заасан баримт бичгийг цахимаар бүрдүүлэн хүргүүлж болно.

7.5. Хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдүүлэх зэргээр тэтгэвэр, тэтгэмжийг үндэслэлгүй, эсхүл илүү тогтоолгож авсан бол үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэвэр, тэтгэмжийг буруутай ажил олгогч, даатгуулагчаар бүрэн төлүүлж нийгмийн даатгалын санг хохиролгүй болгох бөгөөд тэдгээрт холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

## ТАНИЛЦУУЛГА

Журам батлах тухай Засгийн газрын  
тогтоолын төсөл боловсруулсан тухай

2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлд “Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан баримт бичиг болон үйлдвэрлэлийн ослын акт буюу мэргэжлээс шалтгаалсан өвчний тодорхойлолтыг бүрдүүлнэ” гэж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Тэтгэвэр, тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журмыг нийгмийн даатгалын төв байгууллага тогтооно” гэж тус тус заасан.

Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/31 дүгээр “Журам батлах тухай” тушаалыг мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Даатгуулагч тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална” гэж заасан.

Иймд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас даатгуулагч тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журмыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулав.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2022 онд хөдөлмөрийн чадвар алдсан 3568 тэтгэвэр авагчид 27.5 тэрбум төгрөг, тэжээгчээ алдсан 463 иргэнд 3.4 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 1166 иргэнд 1.3 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна. 2023 оны 8 дугаар сарын байдлаар хөдөлмөрийн чадвар алдсан 3515 тэтгэвэр авагчид 19.7 тэрбум төгрөг, тэжээгчээ алдсан 463 иргэнд 2.6 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 967 иргэнд 1.1 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

2023 онд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлого 244.4 тэрбум төгрөг, зарлага 58.9 тэрбум төгрөг, үүнээс оршуулгын тэтгэмжид 606 сая төгрөг тус тус төсөвлөсөн байна.

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар ажил олгогч, даатгуулагч хууль тогтоомжийг нэг мөр ойлгож мөрдөх ба тогтоолыг хэрэгжүүлэхэд улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт санхүүжилт шаардагдахгүй болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ